

## **ISO стандарт, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн харилцан хамааралд хийсэн шинжилгээ**

Д. Содномцог<sup>1</sup>, С. Дэнсмаа<sup>2</sup>

### **Хураангуй**

Чанарын удирдлагын ISO 9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлэх замаар байгууллагын магадлан итгэмжлэлд амжилттай шалгагдах, улмаар хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд эерэг үр дүн гаргах боломжийг судлах хэрэгцээ шаардлага урган гарч байгаа нь энэхүү илтгэлийг бэлтгэх үндэслэл болсон юм.

*Түлхүүр үгс:* чанарын удирдлагын менежмент, магадлан итгэмжлэл, сургалтын хөтөлбөрийн чанар, чанарын баталгаажуулалт

---

<sup>1</sup> ҮБХИС-ийн Цэргийн нэгдсэн сургуулийн Артиллери, зэвсгийн тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд хурандаа

E-mail: sodnomtsog@hotmail.com

<sup>2</sup> ҮБХИС-ийн Дотоод аудит, чанарын үнэлгээний албаны боловсрол, сургалтын чанарын үнэлгээний мэргэжилтэн, докторант

E-mail: densmaa@mndu.gov.mn

## Оршил

Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль (ҮБХИС)-ийн хувьд шинэчлэгдэн өөрчлөгдөх үе шатандаа явж байна. ҮБХИС нь эрхэм зорилгоо: *“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах нийтлэг эрх ашигт нийцсэн цэргийн болон иргэний боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний тэргүүлэх менежменттэй судалгааны их сургууль болох”* гэж тодорхойлон ажиллаж байгаа билээ.

Тус сургууль байгууллагын магадлан итгэмжлэлд орсон байдал, түүний үр дүнд чанарын менежментийн ISO 9001:2015 олон улсын стандартын нөлөөлөл, харилцан хамааралд харьцуулсан шинжилгээ хийхийн тулд судалгаанд тоон болон чанарын аргыг хослон хэрэглэсэн.

Мэдээлэл цуглуулахдаа баримт бичиг судлах аргаар, үндсэн мэдээллийг цуглуулахдаа асуулгыг тэр дундаа ярилцах, стандартчилагдаагүй асуулгаар мэдээлэл авах аргаар цуглуулан ажиглалт ба туршилтын, хагас стандартчилагдсан аргаар үр дүнтэй мэдээлэлд харьцуулалт, задлан шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх аргуудыг хэрэглэв.

## Илтгэлийн үндсэн хэсэг

Монгол Улсын хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүд дотроос дээд боловсролын хурдасгуур хөтлөгч нь боловсрол эзэмшсэн иргэд бөгөөд энэ нь тухайн нийгмийн хөгжил, дэвшлийн баталгаа болж байдаг. Боловсролын цаашдын чиг хандлага ч дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх чадвар бүхий, өндөр бүтээмжтэй мэргэжилтэн бэлтгэхэд чиглэгдэж байдаг. Боловсрол тэр дундаа дээд боловсролын үйлчилгээ чанараар өрсөлдөх шинэ

хэлбэр хандлагатай болон өөрчлөгдөж байна.

Олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэрэгжүүлэх ажил нь сургалт үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах байгууллагын соёлыг бий болгон, нийгэмд нэр хүнд, үнэлэмжийг тогтмол нэмэгдүүлэх боловсролын салбартаа чанараар манлайлагч байх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

ҮБХИС нь 2017 оноос Чанарын менежментийн тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлж хөгжлийн стратегийн хүрээнд олон улсын болон үндэсний стандартад бүрэн нийцсэн сургалт, судалгааг хүний аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд ээлтэй арга зүй технологиор хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулах замаар хувьсан өөрчлөгдөх, хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх зорилгоор чанарын удирдлагын ISO 9001:2015 (MNS ISO:2015) олон улсын стандартыг (Дэнсмаа, 2018) нэвтрүүлээд байна.

Чанарын удирдлагын ISO 9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлснээр ҮБХИС-ийн удирдлагын баримт бичиг шинэчлэгдэж<sup>3</sup>, сургалт эрдэм шинжилгээний ажлыг дотоод чанарын баталгаажуулалттай холбож өгсөн байдаг. Судалгааны үр дүнгээс үзэхэд чанарын менежментийн тогтолцоо нь ҮБХИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, инноваци, дотоод зохион байгуулалт, удирдлагын үйл ажиллагааг сайжруулан, суралцагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх үндэс болж байна.

ҮБХИС нь Монгол Улсын Үндсэн хууль,

<sup>3</sup> ҮБХИС-ийн Дотоод аудит хийх журам

Боловсролын тухай хууль, Монгол Улсын төрөөс батлан хамгаалах талаар баримтлах бодлого болон тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан зарчмыг баримтлан хэрэглэгчдэд боловсролын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, адил тэгш, нээлттэй, үнэлэгдэхүйц хүргэж ажилладаг. Энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл нь хүний хөгжил, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, инноваци, чанарын удирдлага, өөрийн үнэлгээ, сайжруулалтад суурилсан менежмент гэж үзэж байна.

Сонсогч, оюутны сэтгэл ханамжийн судалгаанд 393 оюутан хамрагдсанаас багш нарын мэргэжлийн үр чадвар сайн, оюутанд өгөөжтэй, суралцаж буй хөтөлбөртөө сэтгэл хангалуун байдаг, хичээлүүд үр өгөөжтэй гэж 70 хувь нь хариулсан байна. 2008 оны 4 дүгээр сараас хойшхи хугацаанд хоёр дахь удаагийн магадлан итгэмжлэлээр БМИҮЗ-ийн шинжээчдийн тайланд 8 үзүүлэлтээр 23 зөвлөмж өгсөний дагуу тухайн ажлуудыг сайжруулж, зөвлөмжийг үндсэнд нь хэрэгжүүлсэн байна. Дээд боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийн комисс “Төлөвлөлт, чанарын баталгаажилт” шалгуурыг ҮБХИС “бүрэн хангасан<sup>4</sup>” гэж үзсэн байна.

Боловсролын шинэчлэл, сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд мэдлэг, үр чадвар, чадамжтай, зөв хандлагатай, өөрийгөө байнга хөгжүүлдэг хүний нөөцийг бүрдүүлж ажилласанаар тус сургуулийн ажлын гүйцэтгэлийн чанарт ахиц дэвшил гарч байна.

2018 онд явагдсан магадлан итгэмжлэлд бэлтгэсэн байдал, түүний үр дүнг шинжлэн үзэхэд ҮБХИС нь сургалт, судалгааны ажил үйлчилгээг улам чанаржуулах, мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг байнга дээшлүүлэхийн тулд мэргэжлийн бусад байгууллагуудад суралцагчдыг дадлагажуулах, хамтарсан судалгаа явуулахад анхааран ажиллаж ирсэн байна.

ҮБХИС-д “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015” хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2017 оны 05 сарын 01-ны А/285 захирлын тушаалаар батлагдсан дараах журмуудыг<sup>5</sup> мөрдөн ажиллаж байна. Үүнд:


- Удирдлагын дүн шинжилгээний журам;
- Дотоод аудитын журам;
- Баримт бичиг, бүртгэлийн хяналтын журам;
- Үл тохирлыг залруулах, сэргийлэх журам.

2018 онд байгууллагын магадлан итгэмжлэлд ҮБХИС орсон байдал, түүний үр дүнд чанарын удирдлагын ISO 9001:2015 олон улсын стандартын нөлөөлөл, харилцан хамааралд харьцуулсан шинжилгээ хийх хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ. Бид дээрх хоёр хүчин зүйлсэд эерэг харилцан хамаарал байна гэсэн таамаглал дэвшүүлж, туршилтыг судалгааны нийтлэг жишгээр явуулсан (Авдай нар, 2013) болно. Үүний үр дүнд ISO 9001:2015 олон улсын стандартын нөлөөлөл, харилцан хамааралд эерэг, шууд хамаарал байна гэж үзлээ. (Зураг 1)

<sup>4</sup> ҮБХИС-ийн өөрийн үнэлгээний тайлан

<sup>5</sup> ҮБХИС-ийн вэб сайт

Зураг 1. ISO 9001:2015 стандарт, хөтөлбөрийн харилцан хамаарлын график



Суралцагчийн хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, чадамж, хандлагыг тухайн хөтөлбөрийн зорилго, зорилтуудтай уялдуулж, ямар мэдлэг, ур чадвар, чадамж, хандлагыг сургалтын аль хэсэгт эзэмшихийг матрицад оруулж төлөвлөн мөрдөж байна.

Цахим сургалтын технологийг ҮБХИС-д нэвтрүүлснээр сургалтын хөтөлбөрийн чанар, үр дүнг дээшлүүлэх боломж (Sodnomtsog, 2018) бий болох юм. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг харьцуулан үзвэл дараах байдалтай байна (Хүснэгт 1).

ҮБХИС нь хэрэгжүүлж буй хөтөлбөрүүддээ чанарын дотоод баталгаажуулалт хийх үйл ажиллагааг орц, үйл явц, гарц-үр дүн, үр нөлөөний цогц байдлаар үнэлгээ хийхэд

чиглүүлж ирэв. Сургалтын хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд чанарын баталгаажуулалт хийхдээ их сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, зорилтууд болон дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд хийгдсэн боловсрол олгох мэргэжлийн чиглэлийн нийтлэг шаардлага, хүрэх үр дүнтэй уялдуулан сайжруулж ирсэн байдаг. Судалгааны явцад ISO 9001:2015 стандарт, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн харилцан хамааралд SWOT шинжилгээ хийлээ (Хүснэгт 2).

Чанарын удирдлагын ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх явцад хийсэн дотоод аудитийн тайланд ҮБХИС-ийн бакалаврийн 2-оос доошгүй хөтөлбөр, магистрийн 1, докторын 1 хөтөлбөрийг тус тус магадлан итгэмжлэлд оруулахыг зөвлөсөн байдаг. Сургалтын хөтөлбөрийг чанаржуулахын тулд олон улсын дээд боловсролын хөгжлийн хандлага, нийгмийн эрэлт хэрэгцээг зайлшгүй харгалзан үзэх шаардлага бий болж байгааг зарим судалгааны үр дүн (Долгоржав, 2018) харуулж байгаа юм.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн хүрээнд хийсэн харьцуулсан шинжилгээний үр дүнг үндэслэн хөтөлбөрийн шинэчлэл хийн магадлан итгэмжлүүлэх зарим шинэлэг арга замыг санал болгож болох юм.

Хүснэгт 1. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн харьцуулалт

Уламжлалт хөтөлбөр	Шинэ хөтөлбөр
<ul style="list-style-type: none"> <li>• Хөтөлбөрийн агуулга мэдлэгт тулгуурласан;</li> <li>• Багш төвтэй сургалт зонхилсон;</li> <li>• Мэдлэг дамжуулах технологид түлхүү суурилсан;</li> <li>• Практик ур чадвар эзэмшүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөтөлбөрийн агуулга, зорилго, зорилтууд нь үр дүнд чиглэсэн;</li> <li>• Суралцагч төвтэй сургалт зонхилсон;</li> <li>• Мэдлэг бүтээлгэх, хэрэглэх, туршин хэрэгжүүлэх технологид суурилсан;</li> <li>• Ур чадвар, чадамжийг байнга нэмэгдүүлэхэд чиглэгдсэн.</li> </ul>

Хүснэгт 2. ISO 9001:2015 стандарт, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн харилцан  
хамааралд хийсэн SWOT шинжилгээ

Давуу тал (S)	Сул тал (W)
<ul style="list-style-type: none"> <li>• Чанарын удирдлагын ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлсэн.</li> <li>• Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж ирсэн туршлагатай.</li> <li>• Сургалтын хөтөлбөрүүдэд дотоод чанарын баталгаажуулалт хийдэг.</li> <li>• Хөтөлбөрийн нэгдсэн болон дэд хороод байгуулагдаж үйл ажиллагаа нь жигдэрч байна.</li> <li>• Сургалтын хөтөлбөрүүдийн зорилго, зорилтууд нь үр дүнд чиглэгдсэн.</li> <li>• Хөтөлбөрийг хэрэгжүүлэх материаллаг болон материаллаг бус орчин бүрдсэн.</li> <li>• Сургалтын хөтөлбөр нь мэдлэг дамжуулахаас мэдлэг бүтээх чиглэлд шинэчлэгдэж байна.</li> <li>• Дотоод аудитийн албанд боловсролын чанарын үнэлгээ хийх ажиллагаа тогтмол сайжирч ирсэн.</li> <li>• Цэргийн боловсрол олгох хөтөлбөрийг ур чадвар, чадамжид чиглүүлэн хэрэгжүүлэх хээрийн сургалтын иж бүрэн төвтэй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын хөтөлбөрүүд үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдээгүй.</li> <li>• Цахим, зайн болон виртуал сургалтын орчин бүрдүүлэлт удаашралтай.</li> <li>• Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй.</li> <li>• Интернетийн хурд хангалттай бус, WiFi орчны хамрах хүрээ дутмаг.</li> <li>• Интернетийн мэргэжлийн сургалт явуулах нарийн мэргэжлийн лаборатори дутмаг, техникийн шинэчлэл удаашралтай.</li> <li>• Зарим хөтөлбөрт шаардагдах үндсэн сурах бичиг, ном гарын авлагын фонд бүрдүүлэлт дутмаг.</li> <li>• Багш нарын зарим хэсэг нь сурган боловсруулах үйлчилгээндээ орчин цагийн арга, эв дүй, технологи нэвтрүүлэлт шаардлагын түвшинд зарим талаар хүрэхгүй байна.</li> </ul>
Боломж (O)	Эрсдэл (T)
<ul style="list-style-type: none"> <li>• ISO олон улсын стандартын бусад төрлийг нэвтрүүлэх боломжтой.</li> <li>• Цэргийн хөтөлбөрөөр суралцуулах тогтмол захиалгатай, суралцагчийн эрэлт өндөр.</li> <li>• Мэргэжлийн шинэ хөтөлбөр нээх хэрэгцээ, шаардлага нэмэгдэж байгаа.</li> <li>• Нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу инженерийн хөтөлбөр шинээр нээх, өргөтгөх, хөрвөх чадамж эзэмшүүлэх боломжтой.</li> <li>• Үндсэн хөтөлбөрөөр зохион байгуулах танхимаас гадуурх сургалтын төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын шинэ хөтөлбөр нээхгүй бол элсэн суралцагчдын тоо багасах магадлалтай.</li> <li>• Инженерийн мэргэжлийн сургалт явуулах, орчин техник, технологийн дэвшил нэвтрүүлэхгүй бол өрсөлдөх чадвараа сулруулах эрсдэлтэй.</li> <li>• Иргэний мэргэжлийн хөтөлбөрөөр бэлтгэдэг мэргэжилтний зах зээл дэх нийлүүлэлт нь эрэлтээсээ давсан. Хөтөлбөрийг олон улсын түвшинд хэрэгжүүлэх багш нарын тоо цөөн.</li> </ul>

Дүгнэлт

ҮБХИС-ийн үйл ажиллагааг шинжлэн үзвэл сургалтын хөтөлбөрийг чанарын удирдлагын тогтолцооны нэг элемент болгон өөрчилж ажилласанаар тус сургуулийн ажлын гүйцэтгэлийн байдалд чанарын ахиц дэвшил гарч эхэлсэн гэж үзэж байна.

2017 оноос ҮБХИС-ийн сургалт, судалгааг хүний аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд ээлтэй арга зүй технологиор

хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулах замаар хувьсан өөрчлөгдөх, хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх зорилгоор чанарын удирдлагын ISO 9001:2015 (MNS ISO:2015) олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлсэн нь үр дүнгээ өгч байна.

ISO стандарт, хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хоорондын харилцан хамааралд хийсэн шинжилгээний үр

дүнгээс үзэхэд тэдгээр нь хоорондоо шууд эерэг хамааралтай бөгөөд ҮБХИС-ийн стратеги, хөгжлийн зорилтод ихээхэн дэмжлэг үзүүлнэ гэж дүгнэж байна.

#### Санал

- Чанарын удирдлагын ISO стандарт, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн харилцан хамаарлыг цаашид гүнзгийрүүлэн судлах;
- ҮБХИС-ийн чанарын удирдлагын ISO стандарт, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн харилцан уялдааг хангах чиглэлээр баримтлах зарчмыг тодорхойлох;
- Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үр дүнг сайжруулах, сургалтын хөтөлбөр хэрэгжих орчин, нөхцөлийг дээшлүүлэхийн тулд ҮБХИС-ийн зүгээс харьяа хүрээлэн, сургуулиудыг цэрэг-иргэний зориулалттай орчин үеийн хичээлийн байр, лаборатори, зэвсэглэл техник, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэлээр хангах;
- Цахим, виртуаль зайн сургалтын технологийг нэвтрүүлэх орчинг бүрдүүлж, хөтөлбөр хэрэгжүүлэхэд бүрэн ашигладаг болох зэрэг саналыг дэвшүүлж байна.

#### Ашигласан материал

1. Sodnomtsog, D. (2018). Some Approaches and Possibilities to Introduce Innovation in the Training at the MNDU. *Management & Innovation*. 02(008), 75.
2. Авдай, Ч. & Энхтуяа, Д. (2013). *Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй*. Улаанбаатар: Чулуун бар ХХК.
3. Долгоржав, Ч. (2018). *Дээд боловсролын байгууллагын үйлчилгээний чанар ба оролцогч талууд*. “Боловсролын чанар, үр дүн” олон улсын ЭШХ-ын эмхэтгэл.
4. Дэнсмаа, С. (2018). ҮБХИС-ийн үйл ажиллагаа чанарын удирдлагын тогтолцооны шаардлагыг хангаж байна. “Соёмбо-ҮБХИС” сонины 2018.08.09. 15(125).
5. *Удирдлагын бичиг баримт*. ҮБХИС-ийн вэб сайт.
6. ҮБХИС-ийн Дотоод аудит хийх журам.
7. ҮБХИС-ийн өөрийн үнэлгээний тайлан (2018).